

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

### Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

### БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ:

1. Хүсэлт
2. Төрийн албан хаагчийн анкет
3. Иргэний үнэмлэхний хуулбар
4. Тангарагийн хуудас
5. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг
6. Нийгмийн даатгалын дэвтэр болон шимтгэл төлсөн цахим лавлагаа
7. Тушаал шийдвэрийн хуулбар
8. Эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт
9. Сэтгэцийн эрүүл мэндийн хуудас
10. Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт
11. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний хуудас
12. Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх
13. Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн сертификат

### Материал хүлээн авах:

- Хугацаа: 2023 оны 4 сарын 05-ны өдрийн 17.00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: Татварын ерөнхий газрын 504 тоотод хүлээн авна.
- Холбоо барих утас: **75751288-212, 99142566**

**Татварын ерөнхий газрын харьяа нийслэл, аймгийн татварын албаны төрийн жинхэнэ  
албаны удирдах албан тушаалд шилжүүлэн авах ажлын байрны жагсаалт**

№	Байгууллага	Албан тушаал	Сул орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
				төрөл	ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Нийслэлийн татварын газар	Газрын дарга	1	Эрхэлсэн түшмэл	ТЗ-3	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн удирдлага /041303/</li> <li>- эрх зүй /0421/</li> <li>- санхүү, банк /041201/,</li> <li>- эдийн засаг /0311/,</li> <li>- нягтлан бодох бүртгэл, татвар /0411/</li> <li>- бизнесийн удирдлага /041301/</li> </ul>	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх зохио багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх
2	Завхан аймгийн татварын хэлтэс	Хэлтсийн дарга	1	Ахлах түшмэл	ТЗ-4	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн удирдлага /041303/</li> <li>- эрх зүй /0421/</li> <li>- санхүү, банк /041201/,</li> <li>- эдийн засаг /0311/,</li> <li>- нягтлан бодох бүртгэл, татвар /0411/</li> <li>- бизнесийн удирдлага /041301/</li> </ul>	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх зохио багц сургалтад хамрагдаж төгссөн байх	Төрийн албанд 6-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх